

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Орон нутгийн замын хяналтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Ахлах зохицуулагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-5

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпын гудамж, өөрийн байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг орон нутаг, тууш замын хэмжээнд хариуцаж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн замын цагдаагийн нэгжид замын хөдөлгөөнд хяналт, зохицуулалт хийх, хамгаалалт зохион байгуулах чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллах.

Албан тушаалын зорилт:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг орон нутаг, тууш замын хэмжээнд хариуцаж, аймгуудын болон Багануур, Багахангай, Налайх дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн замын цагдаагийн тасаг /хэсэг-т мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллах;

зааврыг боловсронгуй болгох;

3.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд:	1.1.Аймгууд дахь болон Багануур, Багахангай, Налайх дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтэс, замын цагдаагийн тасаг, хэсэг, Тууш замын хяналтын тасаг, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллах;	Замын хөдөлгөөний зохицуулалт, хамгаалалтын үйл ажиллагаа сайжирсан байна.	Г, Х
	1.2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутгийн захиргааны, төрийн болон төрийн бус байгууллагаас зохион явуулж буй үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах;		Г, Х
	1.3.Зам тээврийн гэмт хэрэг, ослыг бууруулах зорилгоор орон нутаг, хот хоорондын авто зам, тууш зам, уул уурхайн ашигт малтмал тээврийн замын хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, үйл ажиллагаанд шаардагдах хүн хүч, техник, тусгай хэрэгслийн хэрэгцээ, шаардлагын талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэл өгөх;		Г, Х
	1.4.Зам тээврийн гэмт хэрэг, ослыг бууруулах зорилгоор орон нутаг, хот хоорондын автозамын хөдөлгөөнд хяналт тавих, зөрчил илрүүлэх, Зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, шийдвэрлэх;		Г, Х
	1.5.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, орон нутгийн болон тууш зам, уул уурхайн ашигт малтмал тээврийн замын хяналтын чиглэлээр шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруулж, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах;		Г, Х
	1.6.Аймгууд дахь болон Багануур, Багахангай, Налайх дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн замын цагдаагийн тасаг /хэсэг/, Тууш замын хяналтын тасагт хөтлөгдвөл зохих бүртгэл, судалгаа, дотоод албан бичгийн чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх,		Г, Х

	<p>танилцуулах.</p> <p>1.7.Орон нутаг, тууш зам болон уул уурхайн ашигт малтмал тээврийн замын хэмжээнд үйлдэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн статистик мэдээнд тулгуурлан түүнийг бууруулах чиглэлээр тодорхой төрлийн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үр дүнг танилцуулах, тайлагнах.</p>		<p>Г, Х</p> <p>Г, Х</p>
<p>2 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>2.1.Хууль, тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм журмыг сахиулж, замын хөдөлгөөнд хяналт тавих, зөрчлийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр хэлтсийн болон харьяа нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр санал танилцуулах, хариуцан ажиллах;</p> <p>2.2.Олон улсын болон улсын чанартай авто зам болон уул, уурхайн ашигт малтмал тээвэрлэлтийн замын хөдөлгөөнд хяналт тавих, хамгаалалт зохион байгуулах, зөрчил илрүүлэх, шийдвэрлэх үйл ажиллагаатай холбоотой стандарт, дүрэм, журам, зааврын төслийг боловсруулах, боловсронгуй болгох ажилд оролцох, санал танилцуулах;</p> <p>2.3.Олон улсын болон улсын чанартай авто зам, хурдны болон уул, уурхайн ашигт малтмал тээвэрлэлтийн замын төлөвлөлттэй уялдуулан хяналт шалгалтыг шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагыг нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр санал танилцуулах, хэрэгжүүлж ажиллах;</p> <p>2.4.Орон нутгийн, тууш болон уул уурхайн ашигт малтмал тээвэрлэлтийн замын хөдөлгөөнд хяналт тавих, зөрчил илрүүлэх, шийдвэрлэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, гадаад орнуудын туршлагыг судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал санаачилга гаргаж ажиллах.</p>	<p>Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөл боломж сайжирсан байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>3.1.Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, харьяа нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас гаргасан хууль тогтоомж, захирамж, тогтоол, тушаал шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмжийг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлж, биелэлт, үр дүнг тооцох, тайлагнах;</p> <p>3.2.Хэлтсийн чиг үүргийн хүрээнд гудамж замын хяналт, шалгалт, хамгаалалт зохицуулалтын чиглэлээр шаардлагатай</p>	<p>Хэлтсийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p>

	шатны байгууллага, албан тушаалтанд танилцуулах, бусад байгууллагыг мэдээллээр хангах;		Г
	3.3.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, шууд удирдах даргаас хариуцуулсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах;		Г
	3.4.Тээврийн цагдаагийн албаны болон хэлтсийн дотоод журмыг мөрдөж, байгууллагын аюулгүй байдлыг хангах, өмч, эд хөрөнгө, тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, зарцуулалт, ашиглалтын журмыг мөрдөх;		Г
	3.6.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд мөрдөх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдүүлэх, явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах;		Г
	3.6.Авлигын сэжигтэй тохиолдол бүрийг холбогдох албан тушаалтан, байгууллагад мэдээлэх.		Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд боловсролтой, Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	Эрх зүйч /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/, Авто инженерчлэл /071601/.	
Мэргэшил	Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	Цагдаагийн байгууллагад 6-аас доошгүй жил ажилласан, үүнээс офицерын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх. -гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах -судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй
	Асуудал шийдвэрлэх	-өөрийн чиг үүргийн хүрээнд гийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах. -шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг танилцуулах
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох
	Бусад	-Ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх; -Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх; -Англи, Орос хэлний анхан шатны мэдлэгтэй байх; -Компьютерын Microsoft office word8 excel8 power point програмуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх.

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Орон нутгийн замын хяналтын хэлтсийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Батлагдсан орон тоо.	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; Шууд бус харилцах байгууллага: Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална./

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  Т.ГАНЗОРИГ 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	Байгууллагын нэр:..... Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр. Дугаар: 1/но1	
 ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.СҮХБОЛД 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр	

Танилцсан:

Албан тушаалтан:.....

.....

.....

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр